



МОНГОЛ УЛСЫН
ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/218

Улаанбаатар хот

“Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нэмэлт, өөрчлөлт оруулан батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрчим хүчний тухай хуулийн 6.1.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоол, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 18 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд нэгдүгээр хавсралтаар нэмэлт, өөрчлөлт оруулан шинэчлэн баталсугай.

2. Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлтэд үндэслэн компанийн 2025 оны бизнес төлөвлөгөөг баталж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд чиглэл болгосугай.

3. Компанийн техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг үзүүлэлт бүрээр ханган биелүүлж ажиллахыг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн гүйцэтгэх захирал (Х.Ганчулуун)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрчим хүчний сайдын 2025 оны 09 дүгээр сарын 09-ний өдрийн “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2025 оны техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг шинэчлэн батлах тухай А/218 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.



Б.ЧОЙЖИЛСҮРЭН

173600000574

Эрчим хүчний сайдын 2025 оны
09 дугаар сарын 26-ны өдрийн
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**"БАГАНУУР ЗҮҮН ӨМНӨД БҮСИЙН ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨХК-ИЙН 2025 ОНЫ ТЕХНИК,
ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ЗОРИЛТОТ ТҮВШИНД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛСАН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Үзүүлэлт		Хэмжих нэгж	2024 он гүйцэтгэл	2025 он	
					Төлөвлөгөө	Тодотгосон төлөвлөгөө
			х	1	2	3
1	Худалдан авах ЦЭХ		сая кВт.ц	686.7	740.7	772.3
	Түгээлтийн алдагдал	хувиар	хувь	5.8%	6.1%	5.4%
		биетээр	сая кВт.ц	39.7	44.9	42.1
	Борлуулах ЦЭХ		сая кВт.ц	647.0	695.8	730.2
2	Нийт орлого		сая төг	194,010.7	244,331.1	247,455.2
	Үүнээс:	Үйл ажиллагааны орлого	сая төг	154,181.1	196,311.5	209,041.1
		Түгээх үйлчилгээний орлого	сая төг	37,804.4	46,891.6	36,854.4
		Үйл ажиллагааны бус орлого	сая төг	2,025.2	1,128.0	1,559.7
3	Нийт зардал		сая төг	193,406.3	244,097.9	247,443.2
	Үндсэн үйл ажиллагааны зардал		сая төг	191,680.9	242,760.1	245,895.5
	Үүнээс:	ХАЦЭХ өртөг	сая төг	152,397.2	190,885.3	196,585.7
		элэгдэл	сая төг	9,922.8	10,544.6	10,544.6
		бусад тогтмол	сая төг	29,360.9	41,330.2	38,765.2
	Үйл ажиллагааны бус зардал		сая төг	1,725.4	1,337.8	1,547.7
4	Татварын өмнөх ашиг /алдагдал/		сая төг	604.4	233.2	12.0
5	Татварын дараах ашиг /алдагдал/		сая төг	297.6	209.9	10.8
6	Борлуулалтын орлогын 1 төг-т ногдох зардал		төг	1.00	1.00	1.00
7	Нийт авлага		сая төг	2,730.7	927.5	1,534.1
	Үүнээс:	ЭХ-ний	сая төг	2,606.5	927.5	1,534.1
		Бусад	сая төг	124.2	0.0	0.0
8	Нийт өглөг		сая төг	49,996.3	40,200.0	48,694.9
	Үүнээс:	Богино хугацаат өр төлбөр	сая төг	7,862.6	0.0	0.0
		Урт хугацаат өр төлбөр	сая төг	42,133.6	40,200.0	48,694.9
9	Нийт ажиллагсад		тоо	531	565	565
10	Нийт цалингийн сан		сая төг	19,498.7	25,168.5	25,168.5
11	Цахилгаан тасалдлын дундаж хугацаа		минут	808.7	800.0	800.0
12	Их засвар, ТЗБАХ, Хөрөнгө оруулалт		сая төг	5,902.1	7,170.5	7,170.5
	Санхүүжилт	2025 он	сая төг	5,902.1	5,946.4	6,226.7
		2026 он	сая төг	0.0	1,224.1	943.8